

Дархан-Уул аймгийн Засаг даргын зөвлөлийн
2007 оны 4 сарын 02 ний өдрийн хурлаар батлав.

**Дархан-Уул аймгийн „Жимс жимсгэнэ,
хөтөлбөр / 2007-2012/**

**Нэг. “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийг боловсруулах үндэслэл ба
өнөөгийн байдал**

Дэлхийн уур амьсгал дулаарч, цөлжилт идэвхижин улмаар ургамлан нөмрөг сийрэгжин талхлагдахын зэрэгцээ үйлдвэржиж байгаагийн хирээр агаар, ус маш их бохирдож экологийн тэнцвэрт байдал улам бүр алдагдах түүнчлэн хүний болгоомжгүй үйл ажиллагаа зэрэг сөрөг үзэгдлүүдээс болж таримал ургамлын төрөл зүйл, нөөц төдийгүй тоо хэмжээний хувьд багасах аюул нүүрлээд байна.

Жимс жимсгэний ургамал /жимс, навч, холтос, үндсэнд/ нь олон төрлийн амин дэмээр баялаг, будагч бодис элбэг учир хүнс, эмчилгээ сувилгаанд өргөн хэрэглэгддэг төдийгүй ус чийг арвижуулах, гол нуурын эрэг, хөрсийг элэгдлээс хамгаалах, цэцэг, навч, мөчир нь гоёл чимэглэлийн ач холбогдолтойгоос гадна төв суурин газрыг цэцэрлэгжүүлэх, ногоон байгууламжинд танан хэлбэржүүлсэн амьд хашлаганы зориулалтаар таригддаг үнэт таримал юм.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт газар тариаланг сэргээх, тогтвортой хөгжүүлэхэд дэвшилтэт технологи, жимс жимсгэнийг үржүүлэх гол нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, гадаад дотоодын төсөлд хамруулахыг онцлон тэмдэглэсэн байдаг.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тооцоолсноор насанд хүрсэн хүн жилд дундажаар 35 кг, өдөрт 96 г жимс жимсгэнэ хэрэглэх физиологийн норм тогтоосноос манай оронд 1990 оны байдлаар нэг хүнд 12 кг, 1997 оны байдлаар 0.3 кг хүртэл буурч ард түмний хэрэглээ үндсэндээ импортын жимсэн дээр тогтож байгаа нь өнөөдөр жимст цэцэрлэгийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх цэгцтэй бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Жимс жимсгэний ургамал нь хүний биед зайлшгүй хэрэгцээт амин дэм, хүчил, эрдэсийн элементүүдээр баялаг тул тэдгээрийг бусад ямарч ургамлаар орлох боломжгүй. Жимс жимсгэнэ нь өнөөгийн түвшинд "тансаг" харэглээ байхаа больж өдөр тутмын харэглээ болж өөрчлөгдлөө.

Сүүлийн жилүүдэд ажиглагдаж байгаа тариалангийн салбарын уналт жимсний аж ахуйд бүр ч хүндээр тусаж жимст цэцэрлэгийг шинээр байгуулах байтугай хуучин цэцэрлэгийн арчилгаа орхигдож нэгэнт бий болсон талбайн хэмжээ буурч мөн түүнчлэн байгалийн жимс жимсгэний генийн сан, нөөц багасах аюул нүүрлээд байна.

Энэ нь олон хүчин зүйлээс нөлөөлж байгаа боловч тэдгээрийн дотроос тухайн орон нутагт зохицсон өвөл болон хүйтэнд тэсвэртэй, өвчин хорлогчдод тэсвэр сайн, арвин ургацтай жимс жимсгэний сорт үйлдвэрлэлд цөөн байгаа мөн нийт мод бутны 60-70% хөгширсөн, суулгац гаргах үржүүлгийн газрын хүчин чадал хүрэлцээгүй техник хуучирсан зэрэг нь гол шалтгаан болж байна.

Монгол Улсын Засгийн газар нь Ромын 1992 оны "Дэлхийн хоол тэжээлийн тунхаглал"-ыг хүлээн зөвшөөрч "Хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, Монгол хүний хоол тэжээл" Үндэсний хөтөлбөрийг 1994 онд батлан хэрэгжүүлсэн. Гэвч зах зээлийн харилцаанд шилжих эхэн үеийн эдийн засгийн хямрал, хүн амын ядуурал, дахин давтагдаж буй ган зуд зэрэг байгалийн гамшиг болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад нөхцөл байдлыг дутуу үнэлсэн зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан үндэсний хөтөлбөрийн зарим зорилтууд бүрэн хэрэгжиж чадаагүй гэж үздэг.

Иймд Засгийн газрын 237-р тогтоол, 2001 онд ХХААЯамнаас баталсан жимс жимсгэнэ төсөл зэрэгт жимсний аж ахуйг хувийн болон өрхийн чиглэлээр хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж бодлого чиглэл, арга хэмжээг тодорхойлсон юм.

Орчин үед хувийн тохилог орон сууц барьж түүнд төрөл бүрийн жимс жимсгэнэ, чимэглэлийн ургамал яваандаа усан оргилуур, усан сан, нуур цөөрөм гэх мэт нэг хэсэг газар дан хувийн эзэмшилд шилжих хууль эрх зүйн орчин бүрдэж буй өнөөгийн нөхцөлд байгалийн гоо сайхныг хүссэн газартаа зохиомлоор бий болгох шаардлага гарч байгаа учраас жимс жимсгэнэ, чимэглэлийн олон төрлийн ургамлуудыг тариалах улмаар хүмүүсийн эрэлт хэрэгцээг хангахуйц хэмжээгээр үйлдвэрлэх шаардлага гарч байна.

Хоёр. „ Жимс жимсгэнэ „ хөтөлбөрийн зорилго

Жимс жимсгэний тариаланг өөрийн аймгийн онцлогт тохируулан хөгжүүлсний үндсэн дээр хүн амын хүнсний хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай экологийн цэвэр жимс жимсгэний хангамжийг сайжруулах,

өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав., Жимс жимсгэнэ ,, хөтөлбөрийн зорилтууд

- Өрх бүрийг жимс жимсгэний ургамал тариалж өөрсдийн хэрэгцээг хангах цаашид борлуулах нөхцлийг бүрдүүлэх
- Жимс жимсгэнэ, чимэглэлийн ургамлын суулгацыг ургуулах үржүүлгийн газар байгуулах
- Жимс жимсгэнэ, чимэглэлийн ургамлын суулгацыг ургуулах үйл ажиллагааг өргөжүүлэх
- Жимст цэцэрлэгийн талбай байгуулж хүн амыг эрүүл, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах
- Ард иргэд хувьдаа орон сууц барьж жимс жимсгэний ургамлыг тарьж ургуулах сонирхолыг нэмэгдүүлэх
- Жимс жимсгэний хэрэглээг нэмэгдүүлэх

Дөрөв.“Жимс жимсгэнэ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

I үе шат /2007-2009 он/

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн зохион байгуулалт, ард иргэдийг жимс жимсгэний ургамал тариалах чадавхийг бүрдүүлсний үндсэн дээр амины орон сууцанд амьдардаг нийт өрхийн 20-аас доошгүй хувийг жимс жимсгэний ургамал тариалж, ургуулах арга технологид сургаж, эзэмшүүлнэ.
- Жимс жимсгэний ургамлын үржүүлгийн газрыг сум бүрд байгуулна.

II. үе шат /2010-2012 он/

- Эхний үе шатны үйл ажиллгааны явц, байдалд үнэлгээ өгч, ард иргэд, өрхийн жимс жимсгэний ургамлыг тариалж, ургуулах чадавхийг бэхжүүлсний үндсэн дээр амины орон сууцанд амьдардаг нийт өрхийн 20-иас доошгүй хувийг өөрсдийн үржүүлгийн газраас ургуулсан суулгацаар хангана.
- Бүлэг, хоршоо зохион байгуулж, хамтын цэцэрлэг үүсгэн байгуулах хөдөлгөөн өрнүүлнэ.

Тав.”Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах үүргийг “ Ногоон хувьсгал” штаб хэрэгжүүлэх бөгөөд аймаг, сумын түвшинд тухайн шатны хүнс хөдөө аж ахуйн мэрэгжилтнүүд тус тус хариуцна.

Зургаа. “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хөтөлбөрийг иргэдэд сурталчилж, идэвхи санаачлагыг өрнүүлэх
- ЭШБайгууллага, ХААНТөв, мэргэжилтэй болон туршлагатай иргэдийг түшиглэн, сургалт, зөвөлгөө, мэдээллээр хангах үйлчилгээг өргөн олныг хамруулан зохион байгуулах
- Олон нийтийн хэвлэл мэдээлийн хэрэгслээр болон танхимд, талбайд сургалтыг жимс, жимсгэнэ тарьж ургуулах, арчлах, хураах, хадгалах, дахин боловсруулах, хэрэглэх, суулгац бэлтгэх, суулгацыг хадгалах чиглэлээр өргөн хүрээнд зохион байгуулах
- Гарын авлага, зөвлөмжийг иргэдэд ойлгомжтой хялбаршуулсан хэлбэрээр бэлтгэж, хэвлүүлэх
- Сум бүр өөрийн нутаг дэвсгэр дээр жимс жимсгэний үржүүлгийн талбай байгуулж, суулгацаар хангах ажлыг зохион байгуулах
- Жимс жимсгэний үржүүлгийн талбай байгуулахад бага оврын техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх
- Хамтын цэцэрлэг байгуулах чиглэлээр Буриад улсад танилцах аялал зохиож, туршлага судлах

Долоо. “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн санхүүжилт

- Төсвийн хөрөнгө
- Гадаад дотоодын хөтөлбөр, төслүүдийн хөрөнгө
- Хандивын хөрөнгө
- Байгууллага, аж ахуйн нэгжийн хөрөнгө
- Олон нийт, иргэдийн хөрөнгө
- Бусад

Найм: “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн үр дүн

- Жимс жимсгэний ургамлыг тарьж, арчилж, ургуулах, хадгалах, дахин боловсруулах, зохистой хэрэглэх арга ажиллагаанд суралцаж, эзэмшинэ.
- Жимс жимсгэний суулгац үржүүлгийн газар байгуулагдсанаар аймгийнхаа хэрэгцээний суулгацыг дотооддоо үйлдвэрлэдэг болно.

- Жимс жимсгэний үйлдвэрлэл нэмэгдэж, хүн амыг эрүүл, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангана.
- Хотын тохижилт цэцэрлэгжүүлэлтэнд ахиц гарна.
- Цөлжилтийг бууруулах, агаарын бохирдлыг багасгах замаар байгаль орчныг хамгаална.
- Өрхийн орлого нэмэгдэж, ажилгүйдэл, ядуурал буурна.

**ес. „ Жимс жимсгэнэ,, хөтөлбөр хэрэгжүүлэхэд
шаардагдах хөрөнгө / 1 жилээр/**

д/д	Зардлын нэр	тоо	Нэг бүрийн үнэ мян.Г	бүгд мян.Г
1	Зар, сурталчилгаа, самбар	6	10.0	60.0
2	ТВ сургалт 5 минут / бичлэг хийж цацах/	20	15.0	300.0
3	Танхимын сургалт / 40 хүн/	3	200.0	600.0
4	Талбайн сургалт	2	250.0	500.0
5	үзэсгэлэн худалдаа, урамшуулал	1	500.0	500.0
6	Жимс жимсгэний суулгац	2000	5.0	10000.0
7	Мод үржүүлгийн газар	4	6000.0	24000.0
8	Хялбаршуулсан зөвлөмж	500	1.0	500.0
9	Бага оврын трактор	4	2.5	10000.0
10	Усалгааны төхөөрөмж	4	0.6	2400.0
11	Хүлэмж	4	0.8	3200.0
12	Танилцах аялал	10	150.0	1500.0
13	Дүн			

Хөтөлбөр боловсруулсан : агроном

Н.ДЭЛГЭР

Дархан –Уул аймгийн Засаг даргын
Зөвлөлийн 2007 оны 04 сарын 02 ны
өдрийн.... тоот захирамжийн хавсралт

**“Жимс, жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд хийгдэх
“Жимс, жимсгэний үржүүлгийн газар “–ын загвар төсөл**

Төслийн товч танилцуулага

1. Төслийн нэр: Жимс жимсгэний үржүүлгийн газар
2. Төсөл хэрэгжүүлэх салбар: Газар тариалан
3. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Төрийн, ТББ, Хоршоо
4. Төсөл үргэлжлэх хугацаа: 2007-2012 он
5. Төсөл хэрэгжих газар: Дархан, Орхон, Хонгор, Шарынгол сум
6. Төслийн нийт төсөв: 24.0 сая.төг

Төслийн үндэслэл

УГТСЭШХүрээлэнд бага хэмжээний суулгац үйлдвэрлэж байгаа боловч өнөөгийн Жимс жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх эрэлт хэрэгцээг хангах боломжгүй байна. Буриадаас бага хэмжээний суулгац оруулж ирж байгаа боловч хүрэлцээ муу, үнэ өндөр байдаг.

Төслийн зорилго

Жимс жимсгэний үржүүлгийн газрыг байгуулж, суулгацын эрэлт хэрэгцээг дотооддоо хангах үндсэн нөхцлийг бүрдүүлэхэд төслийн зорилго оршино.

Төслийн зорилт

- Үржүүлгийн газартай болох
- Суулгацын эрэлт хэрэгцээг хангах

Төсөл хэрэгжүүлэх үе шат, арга зам

Төслийг 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

Эхний үе 2007-2009 онд Үржүүлгийн газрыг байгуулж, бэхжүүлнэ.

2 дахь үе 2010-2012 онд Суулгац үйлдвэрлэл, хангамжийг сайжруулна.

Төслийн төсөв , эдийн засгийн тооцоо

Жимс, жимсгэний үржүүлгийн газрыг 1 га усалгаатай талбайд байгуулна.

“Жимс жимсгэнэ ” хөтөлбөрийн хүрээнд таримал жимс жимсгэнээс Давжаа алим, Чавга, Монос, Үхэр нүд, Гүзээлзгэнэ, Өрөл, Чацаргана, зэрлэг жимс жимсгэнээс Аньс, Нэрс, Улаалзгана зэрэг жимс жимсгэнэ тариалахаар төлөвлөж байна.

Үржүүлгийн газар үндсэн 3 хэсгээс тогтдог. / Зураг -1 /

- Мөчир, нахиа авах эх цэцэрлэгийн талбай
- Үржүүлгийн талбай
- Хамгаалалтын зурвас

1.Хамгаалалтын зурвас 32% буюу 3192 м²

Таримлын төрөл	Таримлын нэр	1 модны тэжээлийн талбай м ²			Таримлын тоо,ш	Нийт эзлэх талбай м ²
		Эгнээ хооронд,м	Таримал хооронд, м	Эзлэх талбай м ²		
Чимэглэлийн ургамал	Улиас	4	3	12	133	1596
	Хайлаас	4	3	12	133	1596
Бүгд					266	3192

2. Нахиа мөчир авах эх цэцэрлэгийн талбай 29% буюу 2910 м²

Таримлын төрөл	Таримлын нэр	1 модны тэжээлийн талбай м ²			Таримлын тоо,ш	Нийт эзлэх талбай м ²
		Эгнээ хооронд,м	Таримал хооронд, м	Эзлэх талбай м ²		
Үрт жимс 750 м ²	Алим	5	3	15	40	600
	Өрөл	5	3	15	10	150
Яст жимс 750 м ²	Чавга	5	3	15	40	600
	Монос	5	3	15	10	150
Жимсгэнэ 1410 м ²	Үхэр нүд	3	1	3	250	750
	Чацаргана	3	2	6	100	600
	Гүзээлзгэнэ	0.5	0.5	0.25	100	25
	Бөөрөлзгөнө	0.7	0.5	0.35	100	35
Бүгд					650	2910

3. Үржүүлгийн талбай

30% буюу 3000 м²

Үржүүлэх аргууд:

Нугалаадасаар үржүүлэх арга - үхэр нүд, бөөрөлзгөнө

Модлог мөчрөөр үржүүлэх арга - чацаргана

Залгалтын арга – алим, чавга

Сахлаар үржүүлэх арга – гүзээлзгэнэ

Үрээр үржүүлэх арга – монос, өрөл

4. Зам болон сул талбай 9% буюу 898 м²

1 га үржүүлгийн газар байгуулахад хийгдэх ажлууд

№	Хийгдэх ажлууд	Хэмжих нэгж	Ажил явуулах хуанлийн хугацаа	Ажлын биет хэмжээ
1	Бууц татах	тн	IY.20-25	20
2	Бууц цацах	тн	IY.25	20
3	Хагалгаа хийх	га	IY.30	1
4	Борной хийх	га	IY.30	1
5	Шан татах	га	Y.1-3	1
6	Тарилт хийх	ш	Y.3-5	650
7	Хамгаалалтын мод тарих	ш	Y.1-2	266
8	Хог ургамал устгах /4 удаа/	га	YI-YIII	4
9	Бордоо цацах /2 удаа/	га	YII	2
10	Гербицид цацах /1 удаа/	га	YIII	1
11	Усалгаа хийх / 8 удаа/	га	Y-X	8
12	Цас тогтоох	га	XII	1
13				

Үржүүлгийн газарт шаардлагатай материалын зардал

Жимс жимсгэний төрөл		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ, м/төг	
				1 бүрийн	Бүгд
Суулгац	Алим	ш	40	8.0	320.0
	Өрөл	ш	10	1.5	15.0
	Чавга	ш	40	8.0	320.0

	Монос	ш	10	1.5	15.0
	Үхэр нүд	ш	250	1.8	450.0
	Чацаргана	ш	100	1.5	150.0
	Гүзээлзгэнэ	ш	100	1.0	100.0
	Бөөрөлзгөнө	ш	100	1.0	100.0
	Улиас	ш	133	0.5	66.5
	Хайлаас	ш	133	0.8	106.4
	Усалгааны систем	ком	1	1500.0	1500.0
	Бордоо	кг	70	50.0	350.0
	Хашаа	м	400		700.0
	Ажилчидын цалин	төг	53000	106000	106.0
	Жимс жимсгэнэ тариалах зөвлөмж	ш	9000	1.0	9000.0
	Мэрэгжилтний цалин / 5хүн*6 удаа гэрээгээр /	хүн/өдөр	30	24.0	720.0
	Дүн				5918.0

Тайлбар: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд 4 суманд 4 үржүүлгийн газар байгуулахад нийт 22.0 сая.төгрөг шаарлагатай.

Төсөл бэлтгэсэн: агроном

Н.Дэлгэр